**0БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

/2022 оны жилийн эцэс/

2022.11.15

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /сая төгрөг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| **Стратегийн зорилго: Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулах, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэн байгаль, түүх соёлын өвд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болно.** | | | | | | | |
| 1 | **Зорилт 1. Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж, орон нутагт ойн зурвас, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цөлжилттэй тэмцэх талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах** | БХНС АХЗ<br>Аймаг сумдын төсөв,<br>ААНБ, Иргэдийн хөрөнгө | Аймгийн төлөвлөгөөний арга хэмжээний тоо хэрэгжилтийн хувь<br>Тарьсан модны тоо | Шинэ ажил | 52 000 | Төсвийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор БОАЖЯ-аас зарлан санхүүжүүлэхээр төлөвлөгдсөн байсан 20 га талбайн хамгаалалтын ойн зурвасын тендер шалгаруулалтын ажил хойшлогдсон. Батлагдсан стратеги, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөний дагуу 2022 онд нийт 220 аж ахуйн нэгж, байгууллагын 3499 иргэн, 54251 мод бут, сөөг тарьсан.<br>Говьсүмбэр аймгийн хэмжээнд “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд нийт 5.5 сая мод бут сөөг тарих бөгөөд аймгийн газар нутаг, сумдын түвшинд дараах байдлаар хуваарилалт хийсэн.<br>- Сүмбэр сум - 2,8 сая<br>- Шивээговь сум - 0.9 сая<br>- Баянтал сум 0,8 сая<br>- Төмөр замын зурваст 0.5 сая<br>- Шивээ-Овоо ХК - 0.5 сая мод. | ***97.1*** |
| 1.1 | Сум дундын Ойн ангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | БХНС АХЗ<br>14.0 | Арга хэмжээний тоо<br>Зарцуулсан | 7<br>22.2 | 4<br>14.2 | Сум дундын Ойн ангийн үйл ажиллагаанд дараах дэмжлэг үзүүлсэн. Үүнд:<br>1. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Мод үржүүлгийн газарт бороожуулагч усалгааны систем- 19,989.4 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төсөв | | | мян.төгрөг<br>2. Улиас, бургас, сухайн мөчир 32000 ширхэг - 10,020.0 мян.төгрөг<br>3. 4200 ширхэг бортого - 2,919.0 мян.төгрөг<br>4. Ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар ашиглах гүн өрмийн худагт Frog маркын, QJ-4.0 $5^{th}$ 380v out 50 мм үзүүлэлттэй гүний худгийн насос<br>5. Мод үржүүлгийн газрын хортон мэрэгчтэй тэмцэх ажил 1,938.0 мян.төгрөг<br>6. ОНХС-аас 10 тн багтаамжтай усны автомашин 98,000.0 мян.төгрөг<br>7. Ойн зурвас, ногоон байгууламжийн усалгааны зардал<br>- Нийт зарцуулсан төсөв- 132,866.4 мян.төгрөг<br>- Шивээговь суманд шинээр 4 га талбайд хамгаалалтын ойн зурвас, 0.5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулсан.<br>- Ургалт амьдралтын хувь 81 | 100 |
| 1.2 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд усжуулалтын асуудлыг бодлогоор дэмжиж шийдвэрлэх /тарих модны усжуулалт, усалгааны систем, усалгааны автомашиныг шийдвэрлэх / | БХНС АХЗ<br>20.0<br>45.0 | Ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар гаргасан гүний худаг<br><br>Усалгааны системтэй бий болгосон талбай<br><br>Ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар ашиглах ус тээвэрлэх автомашин | Шинэ ажил | 2<br><br>4 га<br><br>1 | Сүмбэр суманд Орон нутгийн хөрөнгө оруулалтаар Ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар 2 гүний худаг гаргасан. Гүйцэтгэгч- "Ус Ундрах" ХХК. Ажлын гүйцэтгэл 100 хувь.<br>Сум дундын Ойн ангид 4 га талбайд зөөврийн бороожуулагч усалгааны систем 19.9 сая төгрөгөөр авсан. Гүйцэтгэгч "Мөнх ногоон тал" ХХК<br>Сум дундын ойн ангид орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 98.0 сая төгрөгөөр ногоон байгууламжийн усалгааны машин авсан. Гүйцэтгэгч Петротрак ХХК<br>**Хүрсэн түвшин:**<br>- Ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар гаргасан гүний худаг: 2<br>- Зөөврийн усалгааны систем бий болгосон талбай: 4 га<br>- Ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар ашиглах ус тээвэрлэх автомашин: 1 | 100 |
| 1.3 | Тэрбум мод үндэсний | БХНС | Шинээр | Шинэ | 1 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, 425 дугаар нээлттэй | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлгөөний хүрээнд шинээр мод үржүүлгийн газар байгуулж, сум дундын ойн ангийн Мод үржүүлгийн газрын хүчин чадлыг нэмэгдүүлэх, тарьц суулгац, үрийн нөөц бүрдүүлэх | АХЗ<br>47.0<br>13.7<br>25.0 | байгуулсан мод үржүүлгийн газар<br>Мод үржүүлгийн газарт дэмжлэг үзүүлсэн тоо<br>Тарьц суулгацын нөөц | ажил<br>1<br>15000 | 1<br>56000 /Мөчир 20000, Үр 18 зүйлийн 105 кг/ | хорих ангитай хамтран 1.5 га талбайд мод үржүүлгийн газар байгуулан 6*20 харьцаатай, 8 хүлэмж шинээр барьсан.<br>БХНСАХЗ-ын 45,000.0 мян.төгрөгөөр Шивээговь суманд 4 га талбайд 4320 мод тарьж, хамгаалалтын ойн зурвас байгуулсан. Сум дундын ойн ангийн Мод үржүүлгийн газарт 40000 ширхэг модлог мөчир, усалгааны шугам хоолой, зөөврийн усалгааны систем, модны бортого, худгийн насос зэрэг 33,746.4.4 мян.төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>- Шинээр байгуулсан мод үржүүлгийн газар 1<br>- Дэмжлэг үзүүлсэн тоо 7<br>- Тарьц суулгацын нөөц: Тарьц 101400, суулгац 115467 | |
| 1.4 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг орон нутагт зохион байгуулж, бүх нийтээр мод тарих аяныг өрнүүлэн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | БХНС АХЗ<br>Аймаг сумдын төсөв,<br>ААНБ, Иргэдийн хөрөнгө | Зохион байгуулсан арга хэмжээний тоо<br>Тарьсан мод бутны тоо<br>Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж<br>Шинээр бий болгосон ногоон байгууламжийн талбай<br>Ургалт, амьдралтын хувь | 3<br>16559 ширхэг<br>82 байгууллага 1121 хүн<br>3,1 га<br>80 хувь | 4<br>56000<br>85<br>2000<br>3,5 га<br>80 хувь | “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”-ий хүрээнд “Ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлтийн анхдугаар зөвлөгөөн зохион байгуулж, БОАЖСайд, газрын дарга, аймгийн удирдлагууд, Цөлжилтийн судалгааны салбарын эрдэмтэн доктор А.Хауленбек, тэргүүтэй албаны хүмүүс, “Хашаандаа сайхан амьдарцгаая” хөдөлгөөний санаачлагч, Ургамлын далай ХХК захирал Ц.Түмэнбаяр, орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллага, иргэн аж ахуйн нэгжийн төлөөллүүд нийт 250 гаруй хүн оролцож, Иргэн бүр мод тарья уриалга, мэдээлэл сурталчилгааны үйл ажиллагаа зохион байгуулсан. Мод, бутны үзэсгэлэн худалдааг 2 удаа зохион байгуулж, “Модны их ургац” ЗБН, сум дундын ойн ангийн Мод үржүүлгийн газар, “Оорцог элгэн” хоршооны орон нутагт үржүүлсэн 17 төрлийн 10000 гаруй мод сөөгөөр иргэдийг хангасан.<br>2022 онд нийт 220 аж ахуйн нэгж, байгууллагын 3499 иргэн, 54251 мод бут, сөөг тарьсан. Шинээр 4 га талбайд ойн зурвас, 0.5 га талбайд цэцэрлэгт хүрээлэн байгуулсан.<br>- Зохион байгуулсан арга хэмжээний тоо: 2<br>- Тарьсан мод бутны тоо: 54251<br>- Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж /давхардсан тоогоор/: 220, иргэн 3499<br>- Шинээр бий болгосон ногоон байгууламжийн талбай: 4 га<br>- Ургалт амьдралтын хувь: 81 хувь | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.5 | Цөлжилтийг сааруулах, газрыг доройтлыг бууруулах зорилгоор хамгаалалтын ойн зурвас байгуулах /Баянтал сум 10 га, Шивээговь сум 4 га, Сүмбэр 10 га/ | - | Ойн зурвасын талбайн хэмжээ<br><br>Тарьсан модны тоо<br><br>Зарцуулсан хөрөнгө | 3.1 га<br>1900<br>21.0 сая | 24 га<br>40000<br>270.0 сая | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах, цөлжилтийг сааруулах, газрыг доройтлыг бууруулах зорилгоор Шивээговь суманд 4 га талбайд 4320 мод тарьж, хамгаалалтын ойн зурвас байгуулсан. БХНСАХЗ-аас 45 сая төгрөг зарцуулсан. Гүйцэтгэгч: Жавхлант аривжих ХХК<br>**Үр дүн:**<br>- Ойн зурвасын талбай хэмжээ: 4 га<br>- Тарьсан модны тоо: 4320, нийт 54251 мод<br>- Зарцуулсан хөрөнгө 45.0 сая төгрөг<br>Төсвийн хэмнэлтийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор БОАЖЯ-аас зарлан санхүүжүүлэхээр төлөвлөгдсөн байсан 20 га талбайн хамгаалалтын ойн зурвасын тендер шалгаруулалтын ажил хойшлогдсон. | 90 |
| 1.6 | Мод тарьж ургуулах 1000 сургагч багш бэлтгэх сургалтад оролцох оролцогчдын сургалтын зардалд дэмжлэг үзүүлэх, иргэн ААНБ-д мод тарьж ургуулах аргыг заах түгээн дэлгэрүүлэх нөхцөл боломжоор хангах | - | Сум тус бүрээс 3 сургагч багш бэлтгэгдсэн байх | Шинэ ажил | **9** | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Мод тарьж ургуулах 1000 сургагч багш бэлтгэхээр Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан сургагч багшийн сургалтад 9 хүн хамрагдсан. Япон улсад бүртгэлтэй “Монголын экологийн мэдээллийн төв” ТББ-тай хамтын ажиллагааны хүрээнд 2 удаа уулзалт зохион байгуулж, аймагт оруулсан хөрөнгө оруулалтын ажлууд, тарьсан модны ургалт, арчилгаа, сум дундын Ойн ангийн мод үржүүлгийн газарт хийсэн хөрөнгө оруулалттай танилцаж, цаашдын хамтын ажиллагааны санал солилцсон. МУБИС-ийн Байгалийн ухааны сургуулийн Ургамлын судалгаа, сургалт арга зүйн төвийн багш Н.Гэрэлчулуун “Хавар, намрын мод тарилтын технологи, модны усалгаа, арчилгаа” сэдэвт сургалт зохион байгуулж, ЕБС-ийн Эко бүлгийн 38 сурагч, Политехникийн коллежийн 21 оюутан, 31 байгууллагын 126 хүн хамрагдсан. Сургалт, практик дадлага ажлыг Политехникийн коллежийн үрслэгээний хүлэмжид зохион байгуулж, мэргэжлийн зөвлөгөө өгсөн.<br>**Үр дүн:** Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мэргэжилтэй ажилтан бэлтгэх зорилт дэвшүүлж, гандуу бүс нутагт мод сөөг тарих арга зүйн зөвлөмж боловсруулагдсан. Цаашид цөлжилтийн судалгааны төвийн үйл ажиллагааг нь өргөжүүлэн Говийн бүсийн инноваци дамжуулах төв болгох зорилт тавин ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.7 | Хашиж хамгаалах, тэмдэгжүүлэх ажилд мод ашиглахаас татгалзах, хуванцар болон бусад хог хаягдлыг ашиглах нөхцлийг бүрдүүлэх, худалдан авалтын бодлогоор дэмжих ТБОНӨХБАҮХАТХ-ийн 10.1.1, 11.1.1 дэх заалтуудыг хэрэгжүүлэх | | Тендерийн даалгаварт тус ажлыг тусгасан тоо<br>Хог хаягдлыг дахин боловсруулж хийсэн хашаа, тэмдэгжүүлэлтийн тоо шонгийн хэмжээ | | 1<br>80-аас доошгүй | Шивээговь суманд байгуулах ойн зурвасын ажлын тендерийн баримт бичигт тусгагдсаны дагуу гүйцэтгэгч Жавхлант аривжих ХХК нь ойн зурвасын хамгаалалтын хашааг төмөр тор болон шонг ашиглан гүйцэтгэсэн. /Нийт 773 ш төмөр шон, 2320 м урт төмөр утсан торон хашаа/<br>Сүмбэр сумын 6 дугаар багт байрлах Ар хажуугийн булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг тухайн багийн малчид, иргэдийн бүлгийн оролцоотойгоор хийж гүйцэтгэсэн. Энэ ажлыг БОАЖЯ-наас өгсөн чиглэлийн дагуу байгальд ээлтэй, хуванцар, гялгар уутыг боловсруулан гаргасан дахивар бүтээгдэхүүн 180 шонгоор гүйцэтгэсэн.<br>Аймгийн хэмжээнд сүүлийн 10 жил бүтээн байгуулалтдаа модон шон ашиглаагүй болно.<br>- Тендерийн даалгаварт тус ажлыг тусгасан тоо 1<br>- Хог хаягдлыг дахин боловсруулж хийсэн хашаа, тэмдэгжүүлэлтийн тоо шонгийн хэмжээ 180 | 100 |
| 2. | **Зорилт 2. Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нөхөн сэргээн нутагшуулах, биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.** | | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо<br>Зарцуулсан хөрөнгө | 1<br>3,0 сая | Дор дурьдсан арга хэмжээний дундаж дүнгээр | Биотехникийн арга хэмжээний тоо - 5<br>- Хужир – 2.5 тн<br>- Өвс - 210 боодол<br>- Оролцсон иргэдийн тоо – 50<br>- Зарцуулсан төсөв 1,2 сая | ***100*** |
| 2.1 | Гадны нөлөөгөөр нөөц хомсдож буй 1 зүйл ургамлын плантаци байгуулах | | 1 зүйл ургамлын плантаци байгуулсан талбай | Шинэ ажил | 0,3 га | Цөлжилтийн судалгааны төвд 7 зүйлийн 9200 гаруй цөлжилтөд тэсвэртэй мод сөөг, ургамал шинээр бортогонд тарьж тус бүсэд ургах боломжтой зарим сөөгийг нутагшуулах туршилтуудыг үргэлжлүүлэн явуулж байна. Хомсдож буй зүйл ургамлаас харганыг сонгон авч 0,4 га талбайд плантаци байгуулан туршсан.<br>Плантаци байгуулсан талбай 0,4 га | 100 |
| 2.2 | Байгаль цаг уурын хүндрэлийг даван туулах зорилгоор зэрлэг амьтдад зориулж | БХНС АХЗ | Өвс<br>Хужир | 200 боодол | 210<br>2,5 тн | Зэрлэг амьтаныг өвс тэжээлийн хомсдолд орохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 5 удаагийн давтамжтай биотехникийн арга хэмжээ зохион байгуулж, нийт 50 хүний бүрэлдэхүүнтэй 210 боодол өвс, 2.5 тонн хужрыг зэрлэг амьтдын байршиж буй 10 байршил газруудад тараан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | биотехникийн арга хэмжээ авах | | Давтамж<br><br>Зарцуулсан төсөв | 2 тн<br><br>5<br><br>3,1 сая | 6<br><br>2.0 сая | байрлуулсан.<br>Хамтран ажилласан байгууллага: ШШГГ 425 дугаар нээлттэй хорих анги, Сүмбэр сумын ЗДТГ, Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл, Боржигин булаг хоршоо<br>**Хүрсэн түвшин:**<br>- Биотехникийн арга хэмжээний тоо - 5<br>- Хужир – 2.5 тн<br>- Өвс - 210 боодол<br>- Оролцсон иргэдийн тоо – 50<br>- Зарцуулсан төсөв 1,2 сая | |
| 3 | **Зорилт 3. Агаар, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж, агаарын чанарын хяналтыг сайжруулна.** | | Агаарын чанарын үзүүлэлтээр | 1 | Дор дурьдсан арга хэмжээний дундаж дүнгээр | “Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журам батлах тухай” 2022.10.21-ны өдрийн А/446, А/290 дугаартай Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Говьсүмбэр аймгийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжаар бүс, журам батлагдсан. | ***100*** |
| 3.1 | Аймгийн төвд агаарын чанарын хяналтыг сайжруулах журмыг мөрдүүлж ажиллах | - | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо<br><br>Журмын хэрэгжилт | 1<br><br>Журам батлагдсан | 2<br><br>90 хувь | “Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журам батлах тухай” 2022.10.21-ны өдрийн А/446, А/290 дугаартай Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Говьсүмбэр аймгийн Засаг даргын хамтарсан тушаал, захирамжаар бүс, журам батлагдсан. Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд байгууллагын цахим хуудас, facebook-т байршуулж, 1000 гаруй иргэнд товч танилцуулга тараасан. Журмын хэрэгжилт 90 хувь<br>**Үр дүн:** Агаарын чанарыг хянах суурь нөхцөл, тогтолцоо бүрдсэн. | 100 |
| 4 | **Зорилт 4. Аймаг, сумдын төвийн хог хаягдлын менежментийг сайжруулах, ахуйн болон тууль хог хаягдал бүхий талбайг бууруулах ажлыг үе шаттайгаар** | | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо<br><br>Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь | 5<br><br>85 хувь | Дор дурьдсан арга хэмжээний дундаж дүнгээр | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ<br>- Агаар орчны бохирдлыг бууруулах 2022 оны арга хэмжээний төлөвлөгөө<br>- Хог хаягдлын менежментийг сайжруулахад талуудын оролцоо зөвлөлдөх уулзалт<br>- Дахивар авах 3 цэг шинээр байгуулагдсан.<br>- Дахивар авах хоршоо байгуулагдсан.<br>- Нөлөөллийн арга хэмжээ 6<br>- Төлөвлөгөөний хэрэгжилт 97.7 хувь | **88.4** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 4.1 | Аймаг, сумдын төвийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн аймгийн төвийн хог хаягдлыг ландфилл технологийн дагуу булшлах | | Арга хэмжээний тоо – 19<br>Хэрэгжилтийн хувь 95 | Арга хэмжээний тоо - 9<br>Хэрэгжилтийн хувь 90 | Арга хэмжээ 9<br>Хэрэгжилтийн хувь 95 | Аймгийн Засаг даргын 2022 оны А/73 дугаар захирамжаар “Агаар, орчны бохирдлыг бууруулах 2022 оны арга хэмжээний төлөвлөгөө”-г 4 зорилт, 9 арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлуулж, дараах арга хэмжээг зохион байгуулсан.<br>- “Хог хаягдлын менежментийг сайжруулахад төрийн байгууллагууд болон олон нийтийн оролцоо” сэдэвт зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл, нийт 65 хүн оролцсон.<br>- Сүмбэр сумын ЗДТГ “Өнгө нэм” ТББ-аар “Хог хаягдлын менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлж хамтран ажиллах гэрээ байгуулж, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөтэй болсон.<br>- Энгийн хог хаягдал цэвэрлэсэн талбай 12 га, төвлөрсөн хогийн цэгт хаясан хог хаягдал 4330 тн<br>- Цэвэрлэсэн туурь хог хаягдал 11 га<br>- Уст цэгийн цэвэрлэгээ 7 удаа: “Уулзвар”-ын гол, “Цоорхой” рашаан, “Хүрий ногоон”, “Хаялага” нуур, “Нэртийн булаг”. Нийт 4.1 га талбайн 23.7 тонн ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэсэн.<br>- Дахивар авах хоршоо байгуулагдаж, 3 цэгтэй болсон. /Сүмбэр суманд 2, Шивээговь суманд шинээр 1 цэг/<br>- Дахивар авах цэгээс Улаанбаатар хот руу нийлүүлсэн дахиврын хэмжээ: хуванцар 5 тн, шил 17510 ш, бор цаас 3 тн<br>- Хог хаягдлыг ангилах ялгах мэдээлэл, сурталчилгаа 17, хамрагдсан иргэн 384, тараасан гарын авлага 200<br>**Хүрсэн түвшин:**<br>- Зохион байгуулсан арга хэмжээ 9<br>- Төлөвлөгөөний хэрэгжилт – 97.7 хувь | 100 |
| 4.2 | Аймгийн хэмжээнд хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах үйл | | Хоёрдогч түүхий эд цуглуулж, | 1 | 2 | “Хог хаягдлын менежментийг сайжруулахад төрийн байгууллагууд болон олон нийтийн оролцоо” сэдэвт зөвлөлдөх уулзалтын үр дүнд дахивар авах, цуглуулах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааг эрчимжүүлж, хоёрдогч түүхий эд цуглуулж, боловсруулж байгаа иргэнийг бодлогоор дэмжиж ажиллах | | боловсруулж байгаа иргэний тоо<br><br>Дэмжлэг үзүүлсэн байдал<br><br>Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ | 1 /Пресслэгч ашиглуулсан/<br><br>2 | 2<br><br>3 | хоршоо байгуулагдсан. “Өнгө нэм” ТББ-тай хамтран ажилласны үр дүнд Сүмбэр сум хог хаягдлын менежментийн төлөвлөгөөтэй болсон.<br>Үр дүн:<br>- Дахивар авах сонирхол бүхий иргэд нэгдэж, Чойр дахивар эрдэнэ хоршоо байгуулсан.<br>- Дахивар авах цэг байгуулагдсан. /Сүмбэр суманд хуучин ОБГ-ын хашааг дэмжлэгээр түр эзэмшүүлсэн. Шивээговь суманд шинээр цэгтэй болсон. /<br>- Шинээр байгуулагдсан хоршоонд 1 пресслэгчийн дэмжлэг үзүүлсэн.<br>- Сургалт, өдөрлөг нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан: 17 байгууллага 85 иргэн<br>- Дахивар авах цэгээс Улаанбаатар хот руу нийлүүлсэн дахиврын хэмжээ: хуванцар 5 тн, шил 17510 ш, бор цаас 3 тн<br>**Үр дүн:**<br>- Хоёрдогч түүхий эд цуглуулж буй байдал: 1 хоршоо /9 хүн/<br>- Дэмжлэг үзүүлсэн байдал 2<br>- Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ 4 | |
| 4.3 | Нутаг дэвсгэрийн хэмжээнд аюултай хог хаягдлын талаар хуулийн хэрэгжилтийг хангаж, хадгалалт хамгаалалтанд хяналт тавьж, аюултай хог хаягдлын тооллого зохион байгуулах | | Хамрагдсан аж ахуйн нэгжийн тоо<br><br>Тооллогын үр дүн<br><br>Хяналт тавьсан тоо | Шинэ ажил | 5<br><br>-<br><br>2 | Аюултай хог хаягдлын үүсгэгч 13 байгууллагыг www.eic.mn сайтад бүртгүүлж, коджуулах ажлыг зохион байгуулсан. Аюултай хог хаягдлын тооллого зохион байгуулах хүрээнд 7 байгууллагад албан бичиг хүргүүлж, 27 төрлийн аюултай хог хаягдлын мэдээллийг нэгтгэсэн. Аюултай хог хаягдлын агуулахын барилга барих ажлын тендерийг БОАЖЯ-нд зарлаж, манай аймагт Ажнай шарга ХХК гүйцэтгэгчээр шалгарч, барилгын ажил эхэлсэн. Гүйцэтгэл 40 хувь.<br>**Үр дүн:**<br>- Аюултай хог хаягдал үүсгэгчийг бүртгүүлснээр судалгаа тооцоолол хийх боломж бүрдсэн.<br>- Хяналт тавьсан тоо: 1 | 90 |
| 4.4 | Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн “9.3.12. Хог хаягдлын олон | | Ажилласан олон нийтийн байцаагчийн тоо | 1<br><br>0 | 1<br><br>3-аас | Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.12 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2020.05.22-ны А/162 дугаар захирамжаар “Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал | 98,7 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журам"-ын хэрэгжилтийг хангах | | Илрүүлсэн зөрчлийн тоо<br><br>Урамшууллын дүн | 1,600.0 мян.төг | доошгүй<br><br>1,800.0 мян.төг | олгох журам" батлагдсан. Сумдад энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэл өгснөөр Шивээговь, Сүмбэр сум хог хаягдлын байцаагч ажиллуулж эхэлсэн.<br>- Ажиллаж байгаа хог хаягдлын олон нийтийн байцаагчийн тоо 2<br>- Илрүүлсэн зөрчил- 5<br>- Олгосон урамшуулал 6,360,000.0 төгрөг | |
| 4.5 | Туурь хог хаягдал бүхий талбайг үе шаттайгаар цэвэрлэнэ. | | Цэвэрлэсэн талбайн хэмжээ - 3,8 | 10 га | 10 га | Туурь хог хаягдалтай талбайн судалгаа мэдээлэлд үндэслэн цэвэрлэгээ, техникийн нөхөн сэргээлт хийсэн.<br>- Шивээговь суманд тээвэр ложистик болон уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 2 компанитай нийгмийн хариуцлагын хүрээнд туурь хог хаягдалтай 5 га талбай цэвэрлүүлсэн<br>- Сүмбэр сумын 1-р багт Аяганы хонхорт 5 га, 3-р багт 1 га туурь хог хаягдал бүхий талбайг цэвэрлэсэн.<br>- Шивээ-Овоо ХК, Ус-Ду ОНҮАГ, Сүмбэр, Шивээговь сумдын ЗДТГ, Алтай рөүд ХХК, Старто ХХК, Тохижилт сүмбэр ОНӨҮГ-тай хамтран ажилласан.<br>**Үр дүн:**<br>- Цэвэрлэсэн туурь хог хаягдалтай талбай 11 га<br>- Хамтран ажилласан аж ахуйн нэгжийн тоо 7<br>- Зарцуулсан зардал 3,498.0 мян.төгрөг | 100 |
| 4.6 | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 445 дугаар тушаалаар батлагдсан "Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар"-ын хэрэгжилтэд хяналт тавих | | Илэрсэн зөрчил<br><br>Зөөж, тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт хаясан хог хаягдлын хэмжээ<br><br>Хяналтын тоо | 0<br><br>521.4 тн<br><br>6 | 1<br><br>-<br><br>7 | "Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах" журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны ээлжит бус 10 дугаар хуралдаанаар оруулж батлуулсан. 2022 оны 11 сарын 01-ний байдлаар "Тохижилт Сүмбэр" ОНӨААТҮГ нь 10.544 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэг рүү 1382 удаагийн рейс хийж төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлсэн. Төвлөрсөн хогийн цэгт байнгын сахиултай болсон. Хог тээвэрлэх үйл ажиллагаанд 4 удаа хяналт тавьж, 2 зөвлөмж өгч ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.7 | Байгаль орчны статистик мэдээллийн маягт /БОХ 6.1; 6.2; 6.3/, түүнийг хэрхэн боловсруулах талаарх сургалт зохион байгуулах | | Зохион байгуулсан сургалтын тоо<br><br>Хамрагдсан сум<br><br>Хамрагдсан албан хаагчийн тоо | 1<br><br>3<br><br>6 | 2<br><br>3<br><br>6 | 2021 оны жилийн эцсийн байгаль орчны статистик мэдээллийг маягтын дагуу системд 2022 оны 2 сарын 14-нд үнэн зөв, хугацаанд нь оруулсан. 2022 оны мэдээллийг 2022.02.15-ны дотор оруулна.<br><br>2022 онд 3 аж ахуйн нэгжийн 4 төсөлд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж дүгнэлт гаргаж, дүгнэлтийг байгаль орчны мэдээллийн сангийн www.eic.mn сайтад оруулсан. Үүнд: Шивээговь сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 2 төсөл, "Алтай рөүд" ХХК-ийн Аймгийн төвийн авто зам барих төсөл, "Язгуур баялаг нэхий" хоршооны Арьс боловсруулах үйлдвэр төсөл.<br><br>- Зохион байгуулсан сургалт 1<br>- Хамрагдсан сум, албан хаагч 3<br>- Мэдээллийн санд оруулсан мэдээлэл 12<br>- 2021 оны мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулсан. | 100 |
| 4.8 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад байгаль орчинд ээлтэй хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах дадал зуршлыг төлөвшүүлэх, хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар сургалт үе шаттайгаар зохион байгуулах | | Зохион байгуулсан сургалт<br><br>Нөлөөллийн үйл ажиллагаа<br><br>Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллага | 2<br><br>3<br><br>14 байгууллага 438 хүн | 4<br><br>3<br><br>20<br><br>500-аас доошгүй | Байгаль орчинд ээлтэй хэрэглээний соёл хэвшүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах дадал зуршлыг төлөвшүүлэх, хүний эрүүл мэнд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах мэдээлэл бүхий сургалт, сурталчилгаа, мэдээлэл, нөлөөллийн үйл ажиллагаа 6 удаа зохион байгуулж, 549 хүн хамрагдсан.<br><br>21 аж ахуйн нэгж байгууллагын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэж, хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшил бий болгох, ангилсан хог хаягдлыг Дахивар авах цэгт өгөх зөвлөмж өгч, ажилласнаар дахивар авах цэгт нийт 21 байгууллага хогоо ангилан ялгаж дахиварт өгсөн байна.<br><br>- Хог хаягдлын талаарх сургалт: 17 байгууллагын 384 хүн<br>- Нөлөөллийн үйл ажиллагаа 6. "Хог хаягдлын менежментийг сайжруулахад төрийн байгууллагууд болон олон нийтийн оролцоо" сэдэвт зөвлөлдөх уулзалт, "Өөрчлөлтийг өөрөөсөө", "Зөв дадал, эерэг өөрчлөлт, ногоон ирээдүй аян, уулзалт, хэлэлцүүлэг, хаягдал сонингоор сагс сүлжих болон бусад сургалт<br>- Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж: 28 байгууллага 549 иргэн<br>- Дахивар авах цэгт хуванцар 5 тн, шил 17510 ш, бор цаас 3 тн, гялгар уут 2 тн цуглуулан, Улаанбаатарт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - боловсруулах үйлдвэрт тээвэрлэснээр хөрсөнд хаягдах хог хаягдлыг бууруулсан.<br>- Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа, хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо 2.3 дахин нэмэгдсэн. | |
| 5 | **Зорилт 5. Усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, усан хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулна.** | | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо<br>Зарцуулсан хөрөнгө | 1<br>- | Дор дурьдсан арга хэмжээний дундаж дүнгээр | Аймаг, сумын хүн амын унд ахуйн усан хангамжийн эх үүсвэрүүдийг 2016 онд орон нутгийн тусгай хамгаалалтад авч төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрүүдэд эрүүл ахуйн бүсийн дэглэмийг оноос хойш мөрдөн ажиллаж байна.<br>Сүмбэр, Шивээговь сумдын Засаг даргын захирамжаар нийт 32 уст цэгт энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөн ажиллаж байна. Зөрчил гараагүй. | ***93.2*** |
| 5.1 | “Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээний аймгийн дэд ажлын хэсгийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах | | Зохион байгуулсан арга хэмжээ<br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 9<br>80 хувь | 9<br>80-аас дээш хувь | “Нөхөн сэргээлт 2024” нэгдсэн арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Цагдаагийн хэлтсийн Экологийн цагдаагийн алба, МХГ, сумдын ЗДТГ-тай хамтран түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын байдалд хяналт шалгалт хийх, хууль бус олборлолт явуулахаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, гарын авлага тараах, эргүүл хийх, эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийлгүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Нөхөн сэргээлтийн 2022 оны мэдээ, тайланг гаргаж БОАЖЯ-нд 2022 оны 11 сарын 04-ний өдрийн 270 дугаар албан бичгээр хүргүүлсэн. “Нөхөн сэргээлт 2024” арга хэмжээний хүрээнд аймгийн Цагдаагийн хэлтсийн Экологийн цагдаагийн алба, Мэргэжлийн хяналтын газартай хамтран хууль бусаар ашигт малтмал ашиглаж буй байдалд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийн дагуу хууль бусаар түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон 1 аж ахуйн нэгжид 2.0 сая төгрөгийн торгууль, 6.1 сая төгрөгийн нөхөн төлбөр ногдуулсан.<br>- Зохион байгуулсан арга хэмжээ 9<br>- Уул уурхайн нөхөн сэргээлт 4.,5 га<br>- Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувь | 100 |
| 5.2 | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч | | Цэвэрлэсэн туурь хог хаягдалтай | 3.8 га | 10 га | Туурь хог хаягдалтай талбайн судалгаа мэдээлэлд үндэслэн цэвэрлэгээ, техникийн нөхөн сэргээлт хийсэн.<br>- Шивээговь суманд тээвэр ложистик болон уул | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болон бусад аж ахуйн нэгжтэй хамтран туурь хог хаягдалтай талбайг цэвэрлэн техникийн нөхөн сэргээлт хийх | | талбай<br>Хамтран ажилласан аж ахуйн нэгжийн тоо<br>Зарцуулсан зардал | 6<br>2,5 сая | 7<br>- | уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 2 компанитай нийгмийн хариуцлагын хүрээнд туурь хог хаягдалтай 5 га талбай цэвэрлэж, техникийн нөхөн сэргээлт хийсэн.<br>- Сүмбэр сумын 1-р багт Аяганы хонхорт 5 га, 3-р багт 1 га туурь хог хаягдал бүхий талбайг цэвэрлэсэн.<br>- Шивээ-Овоо ХК, Ус-Ду ОНҮАГ, Сүмбэр, Шивээговь сумдын ЗДТГ, Алтай рөүд ХХК, Страто ХХК, Тохижилт сүмбэр ОНӨҮГ-тай хамтран ажилласан.<br>**Үр дүн:**<br>- Цэвэрлэсэн туурь хог хаягдалтай талбай 11 га<br>- Хамтран ажилласан аж ахуйн нэгжийн тоо 7<br>- Зарцуулсан зардал 3,498.0 мян.төгрөг | 100 |
| 5.3 | Уул уурхайн улмаас эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийнэ. | | Нөхөн сэргээсэн газрын хэмжээ | 3.8 га | 8 га | Уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж буй “Шивээ-Овоо” ХК Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу энэ онд 4.5 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг хийхээр төлөвлөснөөс 4.5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж талбайг шимт хөрсөөр хучин биологийн нөхөн сэргээлтэд бэлтгэсэн.<br>- Нөхөн сэргээсэн талбай 4,5 га | 56,2 |
| 5.4 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын улмаас эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлт хийлгүүлэх | | Нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ | 3.1 га | 4 га | - Сүмбэр суманд хайрганы олборлолт хийгдэж орхигдсон Улаан цагаан усны эвдэрсэн, хог хаягдалтай 1 га талбайд техникийн нөхөн сэргээлт<br>- Шинээр баригдаж буй Дулааны цахилгаан станцын барилгын ажлын явцад гарсан өнгөн хөрсийг ашиглан Сүмбэр сумын 3 дугаар багт байрлах 2 га ухмал нүх, шуудууг булж тэгшлэн техникийн нөхөн сэргээлт<br>- Алтай рөүд ХХК аймгийн төвийн авто зам барих ажилд ашигласан шар шороон карьерын 0,2 га газарт техникийн нөхөн сэргээлт<br>- Сүмбэр сумын 1-р багт хууль бусаар түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон “Рейлвэй Прожект Энд Консалтинг” ХХК тухайн олборлолт явуулсан 2 га талбайн техникийн нөхөн сэргээлт<br>**Үр дүн:** | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Нөхөн сэргээлт хийсэн талбай 5.2 га | |
| 5.5 | Хууль бус ашигт малтмал олборлолтыг таслан зогсоох хяналт шалгалтыг эрчимжүүлэх | | Хяналт шалгалтын тоо | 3 | 4 | “Нөхөн сэргээлт 2024” нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Цагдаагийн хэлтсийн Экологийн цагдаагийн алба, Мэргэжлийн хяналтын газар, сумдын ЗДТГ-тай хамтран түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын байдалд хяналт шалгалт хийх, хууль бус олборлолт явуулахаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, гарын авлага тараах, эргүүл хийх, эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийлгүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийн дагуу хууль бусаар түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон 1 аж ахуйн нэгжид 2.0 сая төгрөгийн торгууль, 6.1 сая төгрөгийн нөхөн төлбөр ногдуулсан. Нөхөн сэргээлтийн 2022 оны мэдээ, тайланг БОАЖЯ-нд 2022 оны 11 сарын 04-ний өдрийн 270 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| 5.6 | Булгийн эхийг хашиж хамгаалах, тохижуулах ажлыг зохион байгуулах | БХНС АХЗ 6.5 | Хашиж хамгаалсан булгийн тоо | 2 | 1 | 2022 оны Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 6.5 сая төгрөгийн санхүүжилтээр Сүмбэр сумын 5 дугаар багт байрлах Ар хажуугийн булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг тухайн багийн малчид, иргэдийн бүлгийн оролцоотойгоор, байгальд ээлтэй дахивар бүтээгдэхүүнээр хийсэн шонгоор хийж гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувь. | 100 |
| 5.7 | Гадаргын усны тоо бүртгэл зохион байгуулах | | Гадаргын усны тооллогын дүн<br>Тайлан хүргүүлсэн байдал /БОАЖЯ, Усны газарт/ | Усны тоо бүртгэл хийсэн. Үүнд: булаг 20, гол 6, нуур, тойром 9, рашаан 1, хөв, цөөрөм 3, баянбүрд 1, газрын доорх усны орд 7, худаг 433 тоологдсон. | Гадаргын усны тооллогын дүн<br>2 удаа<br>/БОАЖЯ, Усны газарт/ | Аймгийн хэмжээнд гадаргын усны тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулсан. Тооллогоор Сүмбэр суманд 339 худаг, 12 булаг, 2 нуур, 6 гол, 1 рашаан, 1 баянбүрд, 3 хөв, Шивээговь суманд 73 худаг, 8 булаг, 7 нуур, Баянтал суманд 47 худаг тус тус тоологдсон. Гадаргын усны тооллогын тайланг 2022 оны 10 сарын 20-ны 251 албан бичгээр БОАЖЯ-ны Усны газарт хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.8 | Ус хангамж, ариун цэврийн байгууламжид эрсдэлийн үнэлгээ хийж нөхцөл байдлыг тодорхойлох | | Эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн эсэх | Шинэ ажил | Аймгийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрт эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн байна. | Аймгийн Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ хийх ажлын удирдамж боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулсан. Удирдамжийн дагуу эрсдэлийн үнэлгээг холбогдох байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэн, 2023 онд хэрэгжүүлэх шаардлагатай 3 ажлын саналыг төлөвлөлтөд тусгуулахаар аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн. | 90 |
| 6 | **Зорилт 6. Аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо<br><br>Зарцуулсан хөрөнгө | 1<br><br>- | Дор дурьдсан арга хэмжээний дундаж дүнгээр | Зохион байгуулсан арга хэмжээ: 16<br><br>Зарцуулсан зардал: 6,830.0 мян.төг | ***100*** |
| 6.1 | Орон нутгийн онцлог нутгийн иргэдэд түшиглэн түүхэн өв соёл, шашин, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлж, аялалын бүтээгдэхүүнийг сурталчилах | | Зохион байгуулсан боржигин өв соёлын эвент арга хэмжээ<br><br>Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж | Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан зохион байгуулагдаагүй. | 1<br><br>50 | Орон нутгийн онцлогт тохирсон тусгай сонирхлын, байгалийн дурсгалт газар, шашин түүхийн аяллын маршрут тогтоож, “Монгол сакура-Буйлс цэцэглэх хавар” аялал жуулчлалын эвентийн үеэр дараах аялал жуулчлалын бүтээгдэхүүнээр үйлчилсэн.<br>- Улсын тусгай хамгаалалттай газар нутаг Чойрын богд ууланд цэцэглэх буйлс үзүүлэх аялал<br>- Нутгийн иргэдэд түшиглэн морь, тэмээ унуулах<br>- Боржигин өв соёлыг сурталчилсан урлагийн тоглолт<br>- Боржигин уламжлалт идээ, ундааны өв соёл фестиваль<br>- Шашин түүхийн эд хэрэглэлийн өв тээгч, үзүүлэг үзүүлэх<br>- Шагайн болон үндэсний сурын харваа<br>- Боржигин өв музейн үзмэр /цахимаар/<br>- Дугуйн аялал гэх мэт<br><br>Аймгийн Засаг даргын “Түр журам батлах тухай” 2021 оны А/186 дугаар захирамжаар иргэн, малчин өрх, нөхөрлөл, хоршоодын улирлын чанартай амралтын гэр ажиллуулах журам батлуулж, нутгийн иргэдийг аялал жуулчлалд татан оролцуулах, эдийн засгийн нэмэлт орлоготой болгох боломжийг бүрдүүлж, 2022 онд 2 малчин өрх 10 иргэнд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээ үзүүлсэн.<br>**Хүрсэн түвшин:**<br>- Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүний тоо 7<br>- Тусгай сонирхлын аяллын тоо 8<br>- Тусгай сонирхлын аялалд оролцогчдын тоо 3500 | |
| 6.2 | Жуулчны бааз байгуулах санал санаачлагыг дэмжиж мэргэжил арга зүйн удирдлагаа хангаж ажиллана | | Жуулчны баазын тоо<br><br>Хэрэгжүүлэх арга хэмжээ | 1<br><br>1 | 1<br><br>1 | Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын чиглэлээр газар авсан 24 иргэн, аж ахуйн нэгж байгаа бөгөөд Сүмбэр суманд 14, Шивээговь суманд 10 газар эзэмшигч байгаа бөгөөд үйл ажиллагаа тогтмол явуулж буй 1 жуулчны бааз, шинээр 1 түр буудаллах цэг байгуулагдан ажиллаж байна.<br>Аймгийн хэмжээнд “Боржигин голомт” жуулчны бааз үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ЖДҮХС-аас 58.0 сая төгрөгийн ресторан барих зээлийн дэмжлэгт хамрагдсан. Амралтын 15 гэр, байшин, задгай тайз зэрэг бүтээн байгуулалт хийсэн.<br>Оорцог элгэн хоршоо хувийн хөрөнгө оруулалтаар түр буудаллах цэг байгуулан үйл ажиллагаа тогтмолжсон.<br>**Хүрсэн түвшин:**<br>- Жуулчны баазын тоо 1<br>- Дотоодын жуулчдын тоо-15900, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.3 дахин нэмэгдсэн байна.<br>- Гадаадын жуулчдын тоо-87<br>- Түр буудаллах цэгийн тоо 1<br>- Зээлийн дэмжлэг үзүүлсэн байдал - 1 | 100 |
| 6.3 | Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлалын байгууллагуудыг олон улсын болон улсын чанартай үзэсгэлэнд оролцоход дэмжлэг үзүүлэх | | Оролцсон үзэсгэлэн<br><br>Үзэсгэлэнд оролцсон байгууллагын тоо<br><br>Дэмжлэгийн хэмжээ | 2<br><br>4<br><br>1.3 сая | 2<br><br>5<br><br>1.5 сая | Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан “Аялал жуулчлалыг салбарт үйл ажиллагаа явуулдаг жуулчны үйлчилгээний байгууллагууд, тур операторуудын туршлага солилцох аялал жуулчлал бизнес хэлцэл 2022” үзэсгэлэн, арга хэмжээ, ITM 2022 олон улсын үзэсгэлэнд 9 байгууллага оролцож, 12 аяллын компанитай 2023 онд хамтран ажиллах гэрээ байгуулж, аялал жуулчлалын салбарын цаашдын хөгжил, төрөөс барьж бодлого, БОАЖС-тай хийсэн уулзалт ярилцлага, хамтын ажиллагааны үр дүнг хэлэлцсэн 3 өдрийн 10 гаруй арга хэмжээнд хамрагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **Хүрсэн түвшин:**<br>- Оролцсон үзэсгэлэнгийн тоо 2<br>- Үзэсгэлэнд оролцсон ААНБ-ын тоо 9<br>- Дэмжлэг үзүүлсэн 1,303,560.0 төгрөг | |
| 6.4 | Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулж, бүтээгдэхүүн үйлчилгээний чанарыг сайжруулан жуулчдын тоог нэмэгдүүлэх | | Хамрагдсан сургалт<br>Хамрагдсан хүн<br>Жуулчдын тоо гадаад, дотоод<br>Үзүүлсэн дэмжлэг | 4<br>8<br>Гадаад 0<br>Дотоод 14850 | 5<br>10<br>10<br>15000 | Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах сургалтуудад аймгийн Аялал жуулчлалын холбоо, Боржигин голомт жуулчны бааз, зочлох үйлчилгээний салбарын ажилтнууд хамрагдсан.<br>- Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд Засгийн газраас 5 асуудлыг шийдвэрлэснийг орон нутгийн салбарын байгууллагад мэдээллийг 10 байгууллагад хүргэсэн.<br>- “Хамтдаа бүтээлцсэн 30 жил” аялал жуулчлалын салбарын уулзалтад 2<br>- “21 аймгийн Аялал жуулчлалын холбоодын үндэсний чуулга уулзалт”-нд 2<br>- Аялал жуулчлалыг салбарт үйл ажиллагаа явуулдаг жуулчны үйлчилгээний байгууллагууд, тур операторуудын туршлага солилцох “Аялал жуулчлал бизнес хэлцэл 2022” арга хэмжээнд 2<br>- Хорека 2022 /HoReCa/ үндэсний зөвлөгөөн, хуралд 2 хүн, нийт 8 хүн<br>- “Өглөөний цай” уулзалтад 25 хүн хамрагдсан.<br>- Аймгийн Аялал жуулчлалын холбоо, Содура консалтинг ХХК-тай хамтран аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж буй зочлох үйлчилгээний чиглэлийн байгууллагуудад чадавхжуулах сургалтыг 2 үе шаттай зохион байгуулж, “Говьсүмбэр аймгийн хөгжилд аялал жуулчлалын болон бизнесийн салбарын оролцоо, түүний стратеги" сургалтад 10 удирдах албан тушаалтан, "Ёс зүй, харилцаа, хандлага” сургалтад үйлчилгээний 27 ажилтан хамрагдсан.<br>**Хүрсэн түвшин:**<br>- Зохион байгуулсан сургалт 3<br>- Хамрагдсан сургалт 7<br>- Сургалтад хамрагдсан хүний тоо 70<br>- Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн чадавх | 100 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>сайжирсан.<br><table><tr><th>№</th><th>Нэр</th><th>2021</th><th>2022</th></tr><tr><td>1</td><td>Дотоод</td><td>14850</td><td>15900</td></tr><tr><td>2</td><td>Гадаад</td><td>0</td><td>87</td></tr></table></td><td></td></tr>
<tr><td>6.5</td><td>Байгаль, түүх соёлын /Боржигин өв соёл/ арга хэмжээг аялал жуулчлалын эвент үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулахад Соёлын газартай хамтран хэрэгжүүлэх</td><td></td><td>Зохион байгуулсан боржигин өв соёлын эвент арга хэмжээ<br><br>Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж</td><td>Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан зохион байгуулагдаагүй.</td><td>1<br><br>50</td><td>“Монгол сакура-буйлс цэцэглэх хавар” аялал жуулчлалын эвент арга хэмжээг 2022 оны 05 сарын 13-14-ний өдрүүдэд аймгийн ЗДТГазар, Соёл, урлагийн газар, Боржигни чуулга, Боржигин өв музей, аймгийн Аялал жуулчлалын холбоо, “Боржигин голомт” жуулчны бааз, Монголын гастроном” аялал жуулчлалын холбоо, Боржигни түрлэг уртын дууны холбоотой хамтран зохион байгуулсан.<br><br>Эвентийн үеэр “Боржигин идээний уламжлал соёл” фестиваль, Чойрын богд уул буйлс үзүүлэх арга хэмжээ, “Боржигин түмний өргөл” урлагийн тоглолт, Морь, тэмээ унуулах арга хэмжээ, Соёлын бүтээлч үйлдвэрлэл, үйлчилгээ, Боржигин өв музейн үзмэр, өв тээгчийн үзүүлэг, Уламжлалт тоглоом наадгай, Үндэсний сурын болон шагайн харваа зэргийг зохион байгуулсан.<br><br>Үр дүн, үр нөлөө:<br>1. Дотоодын аялагчдын тоо: 3500 хүн, 400 гаруй машин<br>2. Хамтран ажилласан байгууллага, иргэд: 20 байгууллага, 174 хүн<br>3. Аймаг орон нутгийг сурталчилсан тодорхой онцлог бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болсон.<br>4. Аялал жуулчлал, соёлын бүтээлч үйлдвэрлэл, боржигин өв соёлоос сурталчилсан.<br>5. Орон нутгийн хөдөө аж ахуй, үндэсний үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж хамтран ажилласан.<br>6. Байгальд цэвэрхэн аялах, байгаль орчноо хамгаалах сурталчилгаа зохион байгуулснаар энэхүү арга хэмжээнд хог хаягдал бага хаягдсан нь иргэдийн хандлагад өөрчлөлт гарсныг харуулж байна.</td><td>100</td></tr>
<tr><td>6.6</td><td>Аялагч, амрагчдын зүй зохистой аялах соёл дадлыг төлөвшүүлэх</td><td></td><td>Аялагч, амрагчдад зориулсан нөлөөллийн</td><td>Шинэ ажил</td><td>2</td><td>“Аялалд жуучлалдаа бэлдье” уриалга гаргаж дараах арга хэмжээ зохион байгуулсан.<br>- Цахим мэдээлэл 15: Говьсүмбэр Байгаль орчин,</td><td></td></tr>
</table>

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах | | ажил<br><br>Хамрагдсан хүн | | 100 | Говьсүмбэр аймаг facebook, байгууллагын цахим хуудсанд /www.baigal.gs.gov.mn/, www.mto.mn сайт<br>- “Аялал жуулчлалын нөхцөл байдлыг эргэцүүлэн бодож, төлөвлөх нь”телевизийн хэлэлцүүлэг, ярилцлага<br>- Монголын Шагай Холбоо, Говьсүмбэр аймгийн ЗДТГ, ИТХ, Зүүний Хүчний холбоо, аймгийн Музей хамтран Боржигин тойром 2022 шагай харвааны тэмцээн Чойрын Богд уулын энгэрт зохион байгуулсан. “Зөв, цэвэр аялъя” уриалга гарган, ангилан ялгах хогийн сав байршуулж, ил задгай хог хаягдалгүй зохион байгуулсан.<br>- Сургалт: “Зөв аялъя” “Ирлээ, явлаа, цэвэр”, “Би байгальд хог хаяхгүй” самбар. Политехникийн коллеж, 5-р сургуулийн 30 сурагчдад сургалт<br>- Хүний нөөцийг чадавхжуулах сургалт 2, нийт 27 хүн хамрагдсан. /Зочлох үйлчилгээний бизнес эрхлэгч удирдлагуудад “Говьсүмбэр аймгийн хөгжилд аялал жуулчлалын болон бизнесийн салбарын оролцоо, түүний стратеги" сургалт, жуулчны бааз, зочид буудал, худалдаа, үйлчилгээний ажилтнуудад зориулсан "Ёс зүй, харилцаа хандлага" сэдэвт сургалт/ Хамтран ажилласан байгууллага: Аймгийн аялал жуулчлалын холбоо, Содура консалтинг ХХК<br>- Говьсүмбэр аймгийн танилцуулга, аяллын маршрут бусад мэдээлэл бүхий гарын авлагыг QR код болгон цахимаар, цаасаар сурталчилсан. /10 иргэн, аж ахуйн нэгжид байршуулсан./<br>- Улсын тусгай хамгаалалттай Чойрын богд уулын 2 мэдээллийн самбарыг шинэчилсэн.<br>- Боржигин голомт жуулчны бааз тохижилт үйлчилгээгээ сайжруулж, хогийн саваа нэмэгдүүлсэн.<br>- Шивээговь сумын зам дагуух түр буудаллах цэгт доторлогоотой жорлон, хогийн сав байршуулсан.<br><br>**ҮР ДҮН:**<br>1. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийн чадавх сайжирсан.<br>2. Аймгийн аялал жуулчлалын салбарын нэгдсэн видео, QR танилцуулгатай болсон.<br>3. Сургалт, сурталчилгаа 4<br>4. Аялал жуулчлалын эвентийн үеэр ил задгай хог хаягдал гараагүй. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5. ОНХС-аас 1,930.0 төгрөг зарцуулсан | |
| 6.7 | Улсын чанартай А0101 авто зам дагуу байрлах түр буудаллах цэг болох /Шивээговь чиглэлийн стандартын нүхэн жорлонгийн бүхээгийг хийж гүйцэтгэх/ | | Түр буудаллах цэгийн нүхэн жорлонг өөрчилсөн тоо<br><br>Зарцуулсан зардал | Шинэ ажил | 1<br><br>700.0 | Шивээговь чиглэлийн түр буудаллах цэгийн нүхэн жорлонгийн бүхээгийг сайжруулсан. Гүйцэтгэгч Жавхлант арвижих ХХК. БХНСАХЗ-ын 2,3 сая төгрөг | 100 |
| 6.8 | Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал, нүүдлийн мал аж ахуйн уламжлалт соёлд түшиглэн агро аялал жуулчлалыг иргэд, төрийн бус байгууллага, хувийн хэвшилтэй хамтран зохион байгуулах | | Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын тоо<br><br>Хамтран ажилласан иргэн, аж ахуйн нэгж<br><br>Аялагчдын тоо | Шинэ ажил | 3<br><br>3<br><br>250 | Аймгийн Аялал жуулчлалын холбоотой хамтран ажиллах санамж бичиг байгуулж, 2022 онд хамтран ажиллах төлөвлөгөөний гарган хэрэгжүүлсэн. Хэрэгжилт 100 хувь<br>- Монгол сакура Буйлс цэцэглэх хавар эвент арга хэмжээ<br>- Боржигин өв соёлыг сурталчилсан аяллын бүтээгдэхүүн 8<br>- Аялагчдын тоо: 3500<br>- Үзэсгэлэн үзэгчдийн тоо: 1000<br>- Хамтран ажилласан байгууллага, хүний тоо: 20 байгууллага 174 хүн, ТББ 2<br>- Зарцуулсан төсөв: 3,5 сая<br>Монгол сакура-буйлс цэцэглэх хавар" аялал жуулчлалын эвент арга хэмжээний үеэр нутгийн иргэдэд түшиглэсэн, нүүдлийн мал аж ахуйн уламжлалт соёлыг сурталчилсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгох зорилгоор Сүмбэр сумын 2-р багийн иргэн Д.Төгсдорж морь, тэмжээ унуулах үйлчилгээ үзүүлж, морины эмээл, хэрэглэлийг сурталчлан таниулсан. 8 морь, 2 тэмээгээр 500 гаруй иргэнд үйлчилгээ үзүүлсэн.<br>- Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүний тоо 4<br>- Хамтран ажилласан иргэн, аж ахуйн нэгж 4<br>- Аялагчдын тоо 500 | 100 |
| 6.9 | Аялал жуулчлалын салбарын гадаад сурталчилгааг | | Мэдээллийн сан үүсгэсэн | 100 | 100 | Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулж, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулах сургалтуудад аймгийн Аялал жуулчлалын холбоо, Боржигин | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | идэвхижүүлэх Хореко цахим үзэсгэлэн, аялалын маршрут, үзмэр үйлчилгээний мэдээллийг багтаасан Цахим гарын авлага-ын эх бэлтгэлийн боловсруулж www.mto цахим хуудсанд байршуулах | | байх /хувь/ | | | голомт жуулчны бааз, зочлох үйлчилгээний салбарын ажилтнууд хамрагдсан.<br>- Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхэд Засгийн газраас 5 асуудлыг шийдвэрлэснийг орон нутгийн салбарын байгууллагад мэдээллийг 10 байгууллагад хүргэсэн.<br>- “Хамтдаа бүтээлцсэн 30 жил” аялал жуулчлалын салбарын уулзалтад 2, “21 аймгийн Аялал жуулчлалын холбоодын үндэсний чуулга уулзалт”-нд 2, Аялал жуулчлалыг салбарт үйл ажиллагаа явуулдаг жуулчны үйлчилгээний байгууллагууд, тур операторуудын туршлага солилцох “Аялал жуулчлал бизнес хэлцэл 2022” арга хэмжээнд 2, Хорека 2022 /HoReCa/ үндэсний зөвлөгөөн, хуралд 2 хүн, нийт 8 хүн, “Өглөөний цай” уулзалтад 25 хүн , чадавхжуулах сургалтад /2 үе шаттай/ 27 хүн хамрагдсан.<br>- Цахим мэдээлэл, гарын авлага 15: Говьсүмбэр Байгаль орчин, Говьсүмбэр аймаг facebook, байгууллагын цахим хуудсанд /www.baigal.gs.gov.mn/, www.mto.mn сайт<br>- “Аялал жуулчлалын нөхцөл байдлыг эргэцүүлэн бодож, төлөвлөх нь”телевизийн хэлэлцүүлэг, ярилцлага<br>- Говьсүмбэр аймгийн танилцуулга, аяллын маршрут бусад мэдээлэл бүхий гарын авлагыг QR код болгон цахимаар, цаасаар сурталчилсан. /30 иргэн, аж ахуйн нэгжид байршуулсан./<br>**Үр дүн:**<br>- Аялал жуулчлалын салбарын мэдээллийн сан бүрдүүлсэн. | 100 |
| 7 | **Зорилт 7. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг үе шаттай нэмэгдүүлж, менежментийг сайжруулна.** | | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо<br><br>Зарцуулсан хөрөнгө | - | Дор дурьдсан арга хэмжээний дундаж дүнгээр | Хэрэгжүүлсэн арга хэмжээ 2 | ***90*** |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
